



**МОНГОЛ УЛСЫН ШАДАР
САЙД БӨГӨӨД ЭДИЙН ЗАСАГ,
ХӨГЖЛИЙН САЙД**

Засгийн газрын XI байр, Самбуугийн гудамж 11,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас/Факс: (976-51) 26 33 33,
Цахим шуудан: info@med.gov.mn

2024. 01. 09 № 01/54

танай _____-ны № _____-т

**ЗАСГИЙН ГАЗРЫН ХЯНАЛТ
ХЭРЭГЖҮҮЛЭХ ГАЗАРТ**

Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд хандан ирүүлсэн өргөдөл, гомдол шийдвэрлэлтийн 2023 оны жилийн эцсийн тайлан мэдээг хурлаар хэлэлцүүлэн хүргүүлж байна.

Хавсралт..... хуудастай.



Ч.ХҮРЭЛБААТАР

**ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН ЯАМ БОЛОН ТҮҮНИЙ ХАРЬЯА БАЙГУУЛЛАГУУДЫН
ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА, АЛБАН ТУШААЛТАНД ХАНДАЖ
ИРГЭДЭЭС ИРҮҮЛСЭН ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТИЙН
2023 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ТАЙЛАН**

2024 оны 01 дүгээр
сарын 08-ны өдөр

Улаанбаатар
хот

“Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль”, Монгол Улсын Засгийн газрын “Иргэдийн өргөдөл гомдлыг шийдвэрлэхтэй холбогдсон зарим арга хэмжээний тухай” 2005 оны 67 дугаар тогтоолын хүрээнд Эдийн засаг, хөгжлийн яам болон түүний харьяа байгууллагууд /Замын-Үүд чөлөөт бүсийн Захирагчийн ажлын алба, Алтанбулаг чөлөөт бүсийн Захирагчийн ажлын алба, Цагааннуур чөлөөт бүсийн Захирагчийн ажлын алба, Хөрөнгө оруулалт, худалдааны газар/-т **2023 оны жилийн эцсийн байдлаар** иргэдээс төрийн байгууллага болон албан тушаалтанд хандаж ирүүлсэн өргөдөл, гомдлын мэдээ, тайланг нэгтгэн гаргалаа.

Эдийн засаг, хөгжлийн яам болон харьяа газруудад 2023 оны жилийн эцэст нийт 98 өргөдөл, гомдол бичиг хэргээр дамжин байгууллагын албан бичиг хөтлөлтийн программд бүртгэгдсэн байна.

Нийт бүртгэгдсэн **89 өргөдөл, гомдлыг** хуулийн хугацаанд шийдвэрлэсэн бөгөөд өргөдөл, гомдлын шийдвэрлэлт **90.8** хувийн үзүүлэлтэй байна. Одоогоор **3** өргөдөл хуулийн хугацаанд судлагдаж байна.

Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсэгт зааснаар 30 /гуч/ хоногийн хугацааг хэтрүүлж **3** гомдол, **3** өргөдлийг шийдвэрлэсэн байна.

Хугацаа хоцорч шийдвэрлэгдсэн өргөдөл, гомдлын тайлбар хугацааны дарааллаар:

Хугацаа хэтрүүлсэн өргөдлийн тайлбар: 2023 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр “Эрдэнэт Үйлдвэр” ТӨҮГ-ын 3600 уурхайчдаас аж байдал, ахуй амьжиргаа, өр зээл, инфляц үнийн өсөлттэй уялдуулан 2022 оны 13 дахь сарын цалинг хоёр сараар олгож өгөхийг хүссэн хүсэлт гаргасан бөгөөд уг хүсэлтэд хариу албан бичиг боловсруулахад судалгаа хийх шаардлагатай байсан. Тодруулбал, Эрдэнэт Үйлдвэрийн уурхайчид нь төрийн албан хаагчид бус Хамтын гэрээгээр ажилладаг тул Эрдэнэт Үйлдвэрийн Хамтын гэрээг олоход хугацаа шаардагдсан болно.

Хугацаа хэтрүүлсэн Иргэн Э.Батчулууны гомдлын тайлбар: Уг асуудлаар Зам, тээврийн хөгжлийн яам болон төслийн авто замын барилга угсралтын ажилд хяналтын зөвлөхийг хэрэгжүүлж буй Эм Си Пи Си Жи Ар ХХК болон концесс эзэмшигч “Тахилт хайрхан транс” ХХК-нд хандан тодруулга авах албан бичгүүдийг хүргүүлж холбогдох санал, дүгнэлт, тайлбарыг авахад хугацаа шаардагдсан болно.

Хугацаа хэтэрсэн Иргэн Ц.Мөнхжаргалын өргөдлийн тайлбар: Гомдол гаргасан асуудлаар тухайн иргэнээс тодруулга авч, шаардлагатай материалыг цуглуулан Засгийн газрын 2022 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн “Гадаадын хөрөнгө оруулагчдын гомдлыг шийдвэрлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” 413 дугаар тогтоолд нэмэлтээр тусгуулсан тул тухайн ажилд нэмэлт хугацаа шаардагдсан болно.

Хугацаа хэтэрсэн “Жин и Жао” ХХК-ийн гомдлын тайлбар: “Жин и Жао” ХХК-ий гомдлыг удаа дараалан тодруулж, уулзалт зохион байгуулж “Гадаадын хөрөнгө оруулагчдын гомдлыг шийдвэрлэх талаар авах арга хэмжээний тухай” Засгийн газрын тогтоолын төсөлд оруулах эсэхийг судалж, нэмэлт материал цуглуулахад хугацаа шаардагдсан.

Хугацаа хэтэрсэн БНХАУ-ын иргэн Чан Гуо Хуагийн гомдлын тайлбар: Тухайн иргэнээс нэмэлт тодруулга, мэдээлэл авч 2022 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн “Гадаадын хөрөнгө оруулагчдын гомдлыг шийдвэрлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” 413 дугаар тогтоолд нэмэлтээр тусгуулсан тул тухайн ажилд нэмэлт хугацаа шаардагдсан болно.

Хугацаа хэтэрсэн иргэн Б.Энхбаатарын өргөдлийн тайлбар: Иргэн “Б.Энхбаатарын хөлсөөр ажиллах гэрээг дуусгавар болгох тухай” тушаал 2023 оны 08 дугаар сарын 22-ны өдөр гарч, 2023 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөр тасалбар болгосон тул тухайн иргэний 2023 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн хоёр дахь өргөдлийг хүлээн аваагүй.

Тус яамны харьяа Алтанбулаг чөлөөт бүсийн Захирагчийн ажлын албанд гуравдугаар улиралд **1 гомдол** ирснийг хуулийн хугацаанд нь шийдвэрлэсэн байна.

Алтанбулаг чөлөөт бүсийн Захирагчийн ажлын албанд ирүүлсэн “Монсо Чөлөөт бүс” ХХК-ийн гомдол: Тус компанийн 2018 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн А/34 дугаартай захирамжаар авсан газар эзэмших эрхийг сэргээлгэхээр гаргасан гомдлыг “Газрын тухай хууль”-ийн 40 дүгээр зүйлийн 40.1.6 дахь заалт, “Чөлөөт бүсийн тухай хууль”-ийн 12 дугаар зүйлийн 12.5.1 дэх заалтыг тус тус зөрчсөн тул газар эзэмших эрхийг сэргээх боломжгүй тухай хариуг Алтанбулаг чөлөөт бүсийн Захирагчийн ажлын албаны 2023 оны 07 дугаар сарын 20-ны өдрийн 01/226 тоот албан бичгээр хүргүүлсэн.

Хөрөнгө оруулалт, худалдааны газарт 2023 онд 2 гомдол, 7 өргөдлийг иргэд, байгууллагаас ирүүлснийг тус тус хуулийн хугацаанд шийдвэрлэсэн байна.

Эдийн засаг хөгжлийн яам болон түүний харьяа агентлагууд нь гадаадын хөрөнгө оруулалттай холбоотой асуудлыг хариуцаж байгаа тул нийт хүлээн авсан өргөдөл, гомдлын **31.6** хувийг хөрөнгө оруулалттай холбоотой гомдол, санал эзэлж байна. Мөн Засгийн газрын 2022 оны 14 дүгээр тогтоолоор тус яамны үйл ажиллагаа эхэлсэнтэй холбоотойгоор хүний нөөцийг бүрдүүлэх ажил, үйл ажиллагаатай холбоотойгоор “ажилд орох болон чөлөөлөгдөх”-тэй холбоотой өргөдлүүд нийт өргөдөл, гомдлын **40.8** хувийг эзэлж байна.

Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 06 дугаар сарын 08-ны өдрийн 34 дүгээр хуралдаан, 2022 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн 12 дугаар хуралдааны тэмдэглэлд Засгийн газрын гишүүдэд өгсөн үүрэг, даалгаврын дагуу Эдийн засаг, хөгжлийн яаманд ирүүлсэн өргөдөл, гомдлыг “Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль”-ийн 16 дугаар зүйлд заасан хугацаанд шийдвэрлэж байгаа бөгөөд цаашид илүү түргэн шуурхай, иргэдэд хүндрэл чирэгдэлгүй ажиллаж, үйл ажиллагаагаа улам сайжруулахыг зорьж байна.

Жич: Тус яамны харьяа Замын-Үүд, Цагааннуур чөлөөт бүсийн Захирагчийн ажлын албанд 2023 онд иргэдээс Төрийн байгууллага албан тушаалтад холбогдуулан гаргасан өргөдөл, гомдол байхгүй болно.

ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН ЯАМ

ӨРГӨДӨЛ ГОМДЛЫН ТАЙЛАН

Хугацаа: 2023.01.01-2023.12.31

1.Өргөдөл, гомдлын төрөл

1.1 Өргөдөл, гомдлын тайлан

/2023 оны жилийн эцсийн байдлаар/

Байгууллагын нэр	Өргөдөл гомдлын төрөл					Хүлээн авсан хэлбэр				
	Мэдэгдэл	Гомдол	Санал	Хүсэлт	Биеэр	Утсаар	Цахимаар	11-11 төвөөс шилжүүлсэн	Албан бичгээр	
	1	2		3	4				5	
Тайлбар:	Үндсэн хууль, бусад хууль тогтоомжид заасан хүний эрх, эрх чөлөөг хэрэгжүүлэхтэй холбогдон иргэдээс гарсан хүсэлт	Төрийн байгууллага албан тушаалтны шийдвэр, үйл ажиллагаагаар иргэдийн хуулиар хамгаалагдсан эрх чөлөө, ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзэж сэргээлгэх эр гаргасан хүсэлт	Төрийн ба нутгийн удирдлагын байгууллага, албан тушаалтны үйл ажиллагааг сайжруулах, шинэчлэх талаар гаргасан иргэний хүсэлтийг	Дотоод асуудал, үйлчилгээ авах хүсэлтээс бусад	Иргэн өөрийн биеэр ирж, өргөдөл өгсөн	Байгууллагын тусгай дугаараар	Вэб сайт, аппликэйшн, социал флатформ, мэйл г.м	11-11 төвд бүртгэгдэн, цахимаар шилжүүлэн	ААНБ, хуулийн этгээдээс албан бичгээр ирүүлсэн	
Эдийн засаг, хөгжлийн яам	-	27	3	58	-	-	-	31	88	
Худалдаа, хөрөнгө оруулалтын газар	2	2	2	3	-	-	-	-	9	
Алтанбулаг чөлөөт бүсийн захирагчийн ажлын алба	-	1	-	-	-	-	-	5	1	

Хавсралт-2

"Цагааннуур" чөлөөт бүсийн захирагчийн ажлын алба	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
"Замын-Үүд" чөлөөт бүсийн захирагчийн ажлын алба	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-

Хэвсрэлт-3

1.2.2022 оны жилийн эцэстэй харьцуулсан дүн

Байгууллагын нэр	Өргөдөл гомдлын төрөл						Хүлээн авсан хэлбэр			
	Мэдэгдэл	Гомдол	Санал	Хүсэлт	Биеэр	Утсаар	Цахимаар	11-11 төвөөс шилжүүлсэн	Албан бичгээр	
	1	2		3	4				5	
Тайлбар:	Үндсэн хууль, бусад хууль тогтоомжид заасан хүний эрх, эрх чөлөөг хэрэгжүүлэхтэй холбогдон иргэдээс гарсан хүсэлт	Төрийн байгууллага албан тушаалтны шийдвэр, үйл ажиллагаагаар иргэдийн хуулиар хамгаалагдсан эрх чөлөө, ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзэж сэргээлгэхээр гаргасан хүсэлт	Төрийн ба нутгийн удирдлагын байгууллага, албан тушаалтны үйл ажиллагааг сайжруулах, шинэчлэх талаар гаргасан иргэний хүсэлтийг	Дотоод асуудал, үйлчилгээ авах хүсэлтээс бусад	Иргэн өөрийн биеэр ирж, өргөдөл өгсөн	Байгууллагын тусгай дугаараар	Вэб сайт, аппликэйшн, сошиал флатформ, мэйл г.м	11-11 төвд бүртгэгдэн, цахимаар шилжүүлэн	ААНБ, хуулийн этгээдээс албан бичгээр ирүүлсэн	
Эдийн засаг, хөгжлийн яам	-	5	3	101	-	-	-	-	109	
Худалдаа, хөрөнгө оруулалтын газар	-	-	-	-	-	-	-	-	-	
Алтанбулаг чөлөөт бүсийн захирагчийн ажлын алба	-	6	-	22	-	-	1	-	27	
"Цагааннуур" чөлөөт бүсийн захирагчийн ажлын алба	-	-	-	-	-	-	-	-	-	
"Замын-Үүд" чөлөөт бүсийн захирагчийн ажлын алба	-	-	-	26	8	-	-	-	18	

2.Өргөдөл гомдлын шийдвэрлэлт

2.1 2023 оны жилийн эцсийн байдлаар

Шийдвэрлэлтийн байдал										
Шийдвэрлэж хариу өгсөн байдал			Бусад байгууллагад шилжүүлсэн		Хугацаа хэтрүүлэн шийдвэрлэсэн /30 хоног/		Сунгалт хийсэн боловч хугацаа хэтрүүлэн шийдвэрлэсэн /60 хоног/		Хугацаа болоогүй	
Албан бичгээр	Цахимаар	Утсаар	Биечлэн	Харьяаллын дагуу шилжүүлсэн тоо	Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн тоо					Шийдвэрлэх боломжгүй
1	2	3	4							
88	-	3	4	-	-	6		-		3

2.2 2022 оны жилийн эцэстэй харьцуулсан дүн

Шийдвэрлэлтийн байдал										
Шийдвэрлэж хариу өгсөн байдал			Бусад байгууллагад шилжүүлсэн		Хугацаа хэтрүүлэн шийдвэрлэсэн /30 хоног/		Сунгалт хийсэн боловч хугацаа хэтрүүлэн шийдвэрлэсэн /60 хоног/		Хугацаа болоогүй	
Албан бичгээр	Цахимаар	Утсаар	Биечлэн	Харьяаллын дагуу шилжүүлсэн тоо	Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн тоо					Шийдвэрлэх боломжгүй
1	2	3	4							
162	1	-	-	-	-	22		-		5

3. Агуулгын дүн шинжилгээ

Өргөдөл, гомдлын агуулга	Тоо	Хувь	Өргөдөл, гомдлыг бууруулахад цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний санал
Гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдын үйл ажиллагаатай холбоотой	31	31.6%	Хөрөнгө оруулалтын эрх зүйн орчныг сайжруулах, хөрөнгө оруулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг батлуулах
Байгууллагын дотоод асуудал, үйлчилгээ авахаас бусад хэлбэрийн хүсэлт	22	22.4%	Байгууллагуудын үйл ажиллагааг нээлттэй хэлбэрээр иргэд, олон нийтэд таниулахад анхаарч ажиллах
Хөдөлмөр эрхлэлттэй холбоотой	40	40.8%	Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах чиглэлээр хэрэгжүүлэх үйл ажиллагааг нэмэгдүүлэх
Байгууллагын үйл ажиллагаатай холбоотой санал	5	5.1%	Иргэд, байгууллагаас ирүүлсэн саналыг холбогдох удирдлагын түвшинд хэлэлцэж, шаардлагатай санал арга хэмжээг үйл ажиллагаанд тусгах